

Эзэн Богд Чингис хааны тухай
шинэ содон бүтээл

Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Болдбаатар

АНУ-ын Миннесото муж улсын Сант-Паул хотын Макалестер коллежийн Антропологийн салбарын тэргүүн, доктор, профессор Жек Ведерфорд “Өнөөгийн ертөнцийг үндэслэгч, эзэн Чингис хаан” /УБ, 2003/ хэмээх бүтээл анх удаа монгол хэлнээ нийтлэгджээ.

Эл номыг зохиогчийн “Толгод дээрх отог омгууд”, “Америкийн Индианчууд өөр ертөнцөд хэрхэн нэвтэрсэн бэ?”, “Харанхуй бүдүүлэгчүүд ба соёл иргэншил: хэн нь амьдрах вэ?”, “Мөнгөний түүх” зэрэг бүтээлүүд нь англи, герман, испани, швед, орос, португал, хятад хэлээр хэвлэгджээ. Тэрбээр өдгөө АНУ-ын Чингис судлаачдыг тэргүүлж байна. Сайхь профессор бүтээл туурвилаараа АНУ-ын олон байгууллагын томоохон шагналыг хүртжээ.

Жек Ведерфордын энэ удаа толилуулж буй Чингис хааны амьдрал, үйл ажиллагааг түүхэн баримт, судалгаанд тулгуурлан нийтлэлийн хэлбэртэй өгүүлсэн “Өнөөгийн ертөнцийг үндэслэгч, Эзэн Чингис хаан” хэмээх ном нь Чингис судлалд өвөрмөц шинэ содон мөр гарган орж ирж байна.

Энэ бүтээл бол дэлхий дахины эрдэм номын сан хөмрөгийг далайгаас сувд түүх мэт шүүрдэн бясалгасан төдийгүй Монгол нутгаар хөндлөн гулд аялж, Чингис хааны эртний ул мөрөөр мөшгөн сурвалжилсан уйгагүй, нөр их хөдөлмөрийн үр дүн болой. Уг бүтээлийн оршилд доктор Х.Лхагвасүрэн: “Тэрээр /Жек Ведерфорд Ж.Б./ судалгааны бүтээлээ туурвих бэлтгэл ажлын хүрээнд чармайн хөдөлмөрлөж их зүйлийг хийж байсныг мэдэх юм байна. 2001 оны I сарын 2-ны өвлийн хүйтэн /-46⁰/, цээжээр татсан зузаан цасанд /70 см/ Хэнтий аймгийн Биндэр сумын Хархонугийн хөндийд машинтайгаа сууж, Хөвсгөлд үерийн ширүүн урсгалт гол урсаж, хамт алхаж буй нөхрөө харах боломжгүй талын цасан шуурганд, Бурхан Халдуны намагт хөндийд, +48⁰ градус халуун Хонгорын элсэн манханд нэргүй саад, биегүй бэрхшээлийг гэтлэн явахдаа ганц ч удаа ядарч байна гэж ам нээгээгүй эр зоригтой жинхэнэ эрдэмтэн юм” /Зохиолын 5 дахь тал/ хэмээн тэмдэглэжээ. Үүнийг уншиж, тэмдэглэж байхдаа Жекийн маш дөлгөөн тайван байдал, нухацтай харцтай тулгарах шиг болов. Профессор Жек Ведерфорд зохиолынхоо оршил хэсэгт Чингис хааныг анх мэндлэхдээ шагайн чинээ нөж атган төрсөн, хожим дэлхийг байлдан дагуулагч, их хаан болон өсөн дэвжсэн тухай хураангуйлан өгүүлжээ. Тэрбээр: “Дэлхийн түүхэнд түүн шиг /Чингис хаан шиг Ж.Б./ их хүчийг гартаа атгаж, олон хүн ард, олон улс үндэстэн, их газар нутгийг эзэлсэн хүн байхгүй. Чингис хааны эзэнт гүрнийх нь талтай тэнцэх улсыг байгуулсан хүн ч байхгүй. Чингис хааны эзэнт гүрний дэргэд Аугаа Александрын эзэлсэн газар өчүүхэн, бас Цезарь, Наполеоны эзэлсэн нутгууд бараг их гүрнийх нь хошуу нутаг шиг л байсан юм. ЗХУ, АНУ зэрэг өнөөгийн их гүрнүүд ч Монголын эзэнт гүрний хаана ч хүрэхгүй” /Зохиолын 11 дэх тал/ гэж тэмдэглэжээ.

Сайхь профессор оршилынхоо төгсгөл хэсэгт: “Их хааны эх нутаг XX зууны аймшигт технологийн хүрээлүүлсэн атлаа бас хамгаалуулсан нууц арал мэт өнөө үеийг хүрсэн” /Зохиолын 14 дэх тал/ гээд “Тэр нууцыг тайлах түлхүүр нь чухам л энэ Нууц аралд бий.” /Зохиолын 15 дахь тал/ хэмээн бичсэн байна.

Энэ зохиолын I бүлэг “Талыг донсолгосон түгшүүр” нэртэй. Уг бүлэгт: Тэмүжиний бага, өсвөр насны амьдрал, зөрчил тэмцэл, Өүлэн эхийн ухаалаг, зоримог шинжийг түүхэн эссе хэлбэрээр энгийн ойлгомжтой тодорхойлжээ. Бас Хауард Хьюс “Байлдан дагуулагч” кинондоо Өүлэн, Бөртэ хоёрыг булаасан түүхийг ямархан ядраг өгүүлснийг тэмдэглэсэн байна.

“Хайр сэтгэл, яруу алдрын төлөөх тэмцэл” хэмээх II бүлэгтээ Персийн түүхийн нэгэн сурвалжид тэмдэглэсэнчилэн “... Чингис хаан эрийн цээнд хүрээд дайн тулаанд архирах арслан мэт, үймээн самуунд хурц илд мэт болсон” тухай өгүүлжээ. Өөрөөр

Зохиогч Жүзжаны тэмдэглэлээс нэгэн сонирхолтой баримт татсаныг дурдъсу. Чингис хаан нэгэн өдөр Монголын хааны төлөө зүтгэж байсан нэгэн мусульман ламтай ярилцаж суугаад "Миний дараа хорвоо дэлхий дээр аугаа нэр үлдэнэ" гэж хэлжээ. Мөнөөх лам нэлээд эргэлзэж, олон хүний амийг хөнөөсөн учраас нэрийг нь дурсах хүн үлдэхгүй гэж түүнд хариулсанд энэ үг Хаанд огтхон ч таалагдсангүй, "Та сайн ухаараагүй байгаа тань надад тод харагдаж байна. Таны ойлголт өчүүхэн юм. Энэ хорвоо дээр олон Хаан бий ... Бусад эзэнт улсын хаад ноёд, ард түмэн миний түүхийг хүүрнэх болно" гэж хэлсэн ажээ.

Зохиогч VII бүлгээ "**Сүйрэлд орсон эзэнт гүрэн**" хэмээжээ. Үүнд Өгэдэй хааны үйл амьдралыг хөндөөд, Их хуралдай хуралдаж, шийдвэр гарган, монгол цэрэг өмнө зүгт Сүн улсад, баруун өмнө зүгт Перст, баруун зүгт Европт довтолсон тухай авч үзжээ. Эцэст нь тэрбээр: "Монголчууд түүхэнд Ази, Европт хоёуланд нь өргөн уудам газар нутгийг хамарсан их тулааныг нэгэн зэрэг хийсэн анхны улс болоод зогсохгүй, аль алинд нь аугаа их ялалт байгуулсан юм" /Зохиолын 156 дахь тал/ сонирхолтой дүгнэлтэнд хүрсэн байна.

"**Европ руу дахин эргэсэн нь**" гэсэн VIII бүлэгтээ: Матью Парисын бичсэнчлэн "... Тэд /Монголчууд Ж.Б/ христосчуудын нутагт аянга цахилгаан мэт довтолсон" тухай өгүүлжээ. Тухайлбал, Бат хааны цэрэг Волга мөрнийг гаталж, Оросын хотуудыг эзлэн, Унгарын цэргийг хиар цохиж, гайхамшигт Киевийг сөхрөөн, Дунай мөрөнд морьдоо усалж байсныг нүдэнд харагдтал дүрсэлжээ. Бас Невийн Александр Бат хааны өргөмөл хүү байсан, эсэхэд сонирхолтой хариу өгчээ.

"**Хатдын дайн**" хэмээх IX бүлэгт Дөргэнэ хатны Монголын төрийг хамаарсан явдал, Огул Гаймиш, Сорхогтаны зэрэг хатад төрийн жолооноос эс ч цулбуураас нь барьж байсан тухай өгүүлжээ.

Зохиогч "**Шашны хатуу мөрдлөг ба аймшигт дайн**" хэмээх X бүлэгтээ: Мөнх хааны хэрэг явдал, Францийн элч Вильям Рубрук, түүний бичсэн, хэлсэн сонин баримт сэлт, олон шашны урсгалын хуврагууд нэгдэн сөргөлдсөн мэтгэлцэл, мөн Персийн түүхч Жувейн "Дэлхийг байлдан дагуулагч" бүтээлээ хэрхэн туурвисан тухай, Мөнх хааны өрнө, дорно зүг хийсэн аян дайны явдлыг эштэй, баримттай бичжээ.

"**Хубилай хаан урвагч байв уу, аврагч байв уу**" хэмээх XI бүлэгтээ: Хубилай Юан улсыг хэрхэн байгуулж, тохинуулсан тухай сонирхолтой дүгнэлт, гаргалгаа хийсэн байна. Төгсгөлд нь энэхүү шүүмжийг бичигч надтай ярилцсан тухайгаа "Монголыг аврагч" нэрийн дор нэгэн бяцхан зүйл болгон өгүүлжээ. Жөк профессорын бичсэн энэ зүйлд миний ярьсаны тухайд бол Хубилай хааны үйл ажиллагааг сөрөг талаас нь туйлшруулан "урвагч" хэмээн үнэлэгчдэд сануулга өгсөн бодрол, эргэцүүлэл бөлгөө.

Зохиогч: Монголчуудын дэлхий дахины харилцаа холбоо, шинжилгээ судалгаа, худалдаа, соёл, цэргийн зэвсэглэлд оруулсан хувь нэмрийг голлон Марко Пологийн үлдээсэн баримт, нэр алдраар дамжуулан илэрхийлж, "**Марко Пологийн гүүр**" хэмээх XII бүлэгтээ бичсэн юм. Тэрбээр: "Монголчууд Өрнөдөд хэвлэх машин, луужин, сампин, дарь зэргийг түгээн дэлгэрүүлснээр орчин үеийн соёлын төлөөлөгч болж, мөн нэгэн зэрэг Дорно дахинд паалан, цайран шил зэргийг анх таниулсан" /Зохиолын 282 дахь тал/ хэмээжээ. Ингэж монголчууд мэдээлэл харилцааны шинэ эрин үеийн эхлэлийг тавьж, дэлхий дахиныг нам жим зүүрмэглэсэн байдлаас сэрээсэн нь түүхэн үнэн юм.

Жөк Ведерфорд XIII бүлгээ "**Үхэл ба хойт төрөл**" гэж нэрлэжээ. Эл бүлэгт Монголын эзэнт гүрэн задарсан нэг гол шалтгааныг Европ, Азид тахал дэлгэрснээс болсон гэж үзжээ. Тэрбээр: "Эр хүн ба хүлэг морьдын байгуулсан их гүрэн ... мэрэгч ба нохой бөөсөнд бутран унажээ. Тахлын хар аюулын улмаас төв хэсэг байхаа больж, эзэнт гүрний олон хэсэг бүр тус тусдаа бие даах болов" /299 дахь тал/ гэж бичсэн байна.

Уг бүлэгт бас монголчууд аугаа хятад үндэстэн, их Орос гүрнийг бий болгоход гол шийдвэрлэх нөлөө үзүүлснийг ончтой тайлбарлажээ.

Жөк Ведерфорд: Эмир Төмөр, Моголын Бабур нарыг Монголын түүхэнд хэрхэн холбогдох тухайд нэн сонирхолтой гаргалгаа хийсэн байна. Дараа нь монголчуудын төрийн багана хазайсан улс төрийн бутралын үеийг цухас боловч, үндэслэлтэй хөнджээ.

Мөн Чингисийн хойт дүр хэмээн өөрийгөө дөвийлгөх оролдлого гарсаар ирснийг тэмдэглэсэн байна.

Зохиогч уг номынхоо **“Монголчууд өрнөдийнхний нүдээр”** хэмээх XIV бүлэгт: “Марко Поло, Теофрей Чаусер зэрэг сэргэн мандалтын үеийн зохиогчид Монголын түүхийг бичихдээ хүндлэн дээдэлж бишрэн шүтсэн өнгө харагддаг боловч соён гэгээрүүлэлтийн үед бичигдсэн Монголын түүхээс огтхон ч тийм зүйл олдоогүй юм. Харин анх нууцлаг монголчуудыг буг чөтгөр, аймшигт явдлаар тодорхойлж бичсэн Дундат зууны үеийн Европын лам хуврагуудын дүрслэл рүү эргэн орсон байдаг. Европын соён гэгээрүүлэлтийн үеийн эрдэмтэд монголчуудын жигшил, зэвүүцэл, басамжлал, доромжлолыг бий болгон доог хийсэн бөгөөд орчин үеийн шинжлэх ухаан хөгжихөд монголчуудад хандах хандлага улам бүр муудсан юм”. /Зохиолын 330 дахь тал/ гэж дүгнээд, “Монгол төрхийг гутаасан нь”, “Монголжуу зүсийн тухай америк ойлголт”, “Монгол төрхтөн-тэнэг монголчууд”, “Өрнийн монголчууд”, “Шарын аюул” зэрэг зүйлүүддээ монгол төрхтөн хэмээх ангилал яаж бий болсон, “Монгол” хэмээх нэр бүхий л аймшигтай муухай, соёлгүй, бүдүүлэг, бас Азийнхны сөрөг шинжийг заасан оньсон түлхүүр үг болон хувирсан тухай олон ном зохиол уйгагүй шүүрдэн үзэж, түүхчлэн өгүүлжээ. Энэ нь монгол уншигчдад өөрсдийгөө ойлгох гүн ухаарлыг төрүүлэх буйзаа. Харин Жек Ведерфорд бол монголчуудыг тэс өөрөөр үздэг бөгөөд биднийг тууштай, баталгаатай, өмгөөлөн хамгаалагч гэдгийг зориуд тэмдэглэн хэлмээр байна.

“Чингис хааны цэвэрлэгээ” хэмээх XV бүлэгтээ: зохиогч Чингис хааныг жинхэнэ ёсоор нь үнэлэх гэсэн хэн боловч, үндсэрхэг үзэлтэн болон хэлмэгдэж байсан гунигт үеийн тухай өгүүлжээ. Үүнийг тэрбээр “Түүхийн эсрэг дайн” хэмээн ончтой нэрлэсэн байна.

1980-аад оны эцэс 1990-ээд оны эхээр өрнөсөн ардчилсан хөдөлгөөний үр дүнд Монголчууд Чингис хаанаа буцааж авсан юм гэж Жек Ведерфорд бичсэн байна. Тэрбээр сүүлчийн бүлгийнхээ төгсгөлд: “... Тэмүжиний үйлс эцэстээ дэлхийг бүхэлд нь өөрчлөн байгуулснаар төгсгөл болж, харин түүний эх нутаг нь яг тэр хэвээрээ байсаар ажээ.” /Зохиолын 366 дахь тал/ гэж тэмдэглэжээ.

Зохиолч номынхоо дүгнэлт хэсэгт Чингис хаан эдүгээгийн даяаршлын эхийг тавигч, өнөөгийн ертөнцийг үндэслэгч хэмээгээд “Монголчууд салангид орших олон соёл иргэншилт ертөнцийг эцэс болгожээ. Монголчуудаас хойш тэдгээр соёл иргэншлүүд дахин ангид тусдаа огт яригдаагүй ба Перугээс эхлээд Сибирь хүртэл бүгд дэлхийн нэгдмэл тогтолцоонд нэгдсэн юм” /Зохиолын 364 дэх тал/ гэж дүгнэжээ.

Профессор Жек Ведерфорд номоо түүхэн нийтлэл, эссе хэлбэрээр уран чадмаг, уншууртай бичжээ. Энэ нь монголын түүхчдэд нэгийг бодогдуулах буйзаа.

Эл зохиолыг амьд сонирхолтой болгоход Жек Ведерфордыг Чингис хааны амьдрал, үйл ажиллагаатай холбоотой нутгаар хөтөч болгон дагуулж, санаа, оноогоо харамгүй хуваалцсан доктор Х.Лхагвасүрэн, профессор О.Сүхбаатар, Х.Шагдар зэрэг хүмүүсийн хичээл зүтгэл ихэд нөлөөлснийг тэмдэглэхгүй өнгөрөх аргагүй юм.

Уг номыг англиас монгол хэлнээ боломжийн утга төгөлдөр хөрвүүлсэн орчуулагч бүсгүй А.Мөнгөнзулд монгол хүн бүр зүй ёсоор талархах ёстой.

Энэ дашрамд энэ номыг дахин хэвлүүлвэл хэрэг болохсон болов уу хэмээх үүднээс ганц нэг жижиг зүйл хэлье. Ном бүтээхдээ ашигласан эх сурвалж, ном, зохиолуудыг тодорхой хэлж өгвөл тун өгөөжтэй болох байж. Учир нь эл бүтээлд монголын түүхийн судалгааны эргэлтэд урьд өмнө тэр бүр орж байгаагүй шинэ содон сурвалж, ном зохиол нэлээдийг ашиглажээ. Мөн “винтовоор тарвага буудсан” /тарвагыг калибраар алдаг, винтовоор буудсан тарвага юу ч үлддэггүй/, “монгол үндэстнийг байгуулсан” /үндэстэн бүрэлддэг/, “Барон Унгерн 1923 онд Монголд орж ирсэн” /1920 онд Монголд орж ирсэн/ зэрэг оновчтой биш өгүүлбэр, алдаатай он цаг мэр сэр тааралдаж байгаа нь орчуулгын болон хэвлэлийн алдаа болов уу.

XXI зууны гараан дээр профессор Жек Ведерфордын туурвисан “Өнөөгийн ертөнцийг үндэслэгч Эзэн Чингис хаан” хэмээх бүтээл нь ийнхүү Чингис судлалд шинэ өнгө аяс, хүчит түрлэг, үнэний өчил болон орж ирлээ. Мэдэгтүн!, Судлагтун!